

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 06 дугаар сарын 26-ны “Даваа” гарагийн 12:00 цагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т word файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлтийг хугацаа хэтрүүлж ирүүлэхгүй байхад анхаарна уу, хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд хүлээн авч, нэгтгэлд оруулахгүй болно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1	Нийслэл, дүүргийн төсвийн тодотголын бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ААНБ-ууд
2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын уялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллах	ТХҮХ СТСХ, ХААА
3	Дүүргүүд нийслэлд төвлөрүүлэх төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
4	2023-2024 оны өвөлжилтийг бэлтгэл ажлыг сайтар хангаж, инженерийн шугам, сүлжээний ажлуудыг эрчимжүүлж ажиллах.	ЗДО Б.Болормаа ТХҮХ
5	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсээс мал бүхий иргэдийг гаргах ажлыг тогтмол зохион байгуулах.	ТХҮХ ХААТ ГЗБА
6	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжийн дагуу 40 байршилд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ
7	Авто замын хайс, хашлага, тэмдэг, тэмдэглэлээг стандартын дагуу будаж, засварлах ажлыг эрчимжүүлж ажиллах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
8	Зам тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төвөөс 07 дугаар сарын 01-нээс өмнө ашиглалтын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулж буйтай холбогдуулан НЗД-ын 2023 оны 402 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжуудын хүрээнд тээврийн хэрэгслийн үзлэг тооллогод идэвхтэй хамрагдах, иргэдэд мэдээллийг хүргэх	ААНБ-ууд Хороод
9	Нийслэлийн төсвийн тодотголд төсвийн давсан орлогоос авто болон явган зам засвар, тохижилтын ажлуудыг нэмэгдүүлэх хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой тухай яригдсан тул дүүргийн нутаг дэвсгэрт дээрх ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байршлуудын мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн саналуудын талаар тодруулж ажиллах	ЗДО Б.Болормаа, ТХҮХ

10	Байгууллагын болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг тогтмолжуулж, усан оргилуурыг бүрэн ажиллуулах, тоосжилтыг арилгах хүрээнд орчны агаарыг чийгшүүлэх ажлыг зөв зохистой зохион байгуулж ажиллах	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, ААНБ-ууд
11	Засгийн газрын “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, халамжийн сангаас олгогдож буй зээл тусламж, дэмжлэгийн талаарх мэдээ мэдээллийг нэгтгэн танилцуулах.	ХХҮХ
12	Дүүргийн баяр наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, баяр наадмын бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ЗДТГ